

# Монгол хүний тэтгэврийн насны судалгаа, прогноз

Н.Тунгалаг, МУИС-ийн ЭЗС-ийн багш, доктор (Ph.D), профессор  
Ч.Дагвадорж, НХХЯ-ны газрын дарга, доктор (Ph.D)

Монгол улсын нийгмийн даатгалын хуулийн дагуу 60 нас хүрсэн, нийгмийн даатгалын шимтгэлийг зохих хугацаанд төлсөн иргэн тэтгэвэр тогтоолгох эрхтэй боловч ажлын онцлог, хөдөлмөрийн нөхцөл, хүйс зэргээс хамаарч иргэд харилцан адилгүй наснаас тэтгэвэр тогтоолгож байна. Тэтгэврийн насны хүн ам 2000 онд 153.8 мянга байсан бол 2025 он гэхэд 434.5 мянга болж 2000 оноос 1.8 дахин өсөх төлөвтэй. Тэтгэврийн насны хүн ам 2000-2005 онд 12.7 хувь өсч байснаа 2010-2020 онд 33.5 хувь болж эрс өсч, харин 2025 онд 29.8 хувь хүртэл бага зэрэг буурах хандлага ажиглагдаж байна. Иймд Монгол хүний хөдөлмөрийн чадвараа бүрэн ашиглаж чадах насанд нөлөөлж байгаа нийгэм, ахуйн хүчин зүйлийн талаар олон нийтийн санал, бодлыг судлах, тэтгэврийн насны зохистой харьцааны байдал, тэтгэврийн нас болон ажил, мэргэжлийн ялгаамжтай байх зарчим үндэслэл, үр дагаврыг тодотгох, санал дэвшүүлэх зорилгоор энэхүү судалгаа хийгдсэн. Судалгаанд Улаанбаатар хотын 6 дүүрэг, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий, Увс, Сэлэнгэ, Орхон аймгийн нийт 2436 хүн хамрагдла.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэтгэвэр тогтоолгох насны тухайд оролцогчдоос авсан судалгааны үр дүн дараах байдалтай байна. Үүнд: эрэгтэй хүний тэтгэвэрт гарах хамгийн зохимжтой нас 60 гэж судалгаанд хамрагдагчдын 67.0 хувь нь, эмэгтэй хүний тэтгэвэрт гарах хамгийн зохимжтой нас 50-59 нас гэж 87.6 хувь нь үзжээ. Мөн тэтгэвэр тогтоолгохын тулд эрэгтэй, эмэгтэй ялгаагүй 20-иос дээш жил ажилласан байх ёстой гэсэн нийгмийн даатгалын хуульд заасан заалттай дийлэнхи нь санал нэг байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэтгэвэр тогтоолгох нас ялгавартай байгааг өөрчилж, адил насандаа тэтгэвэр тогтоолгодог болохыг нийт судалгаанд оролцогчдын 37.4 хувь нь зөв, 55.1 хувь нь буруу, 7.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Тэтгэврийн насыг ижил байлгах нь зөв гэж үзсэн хүмүүсийн 20 гаруй хувь нь эмэгтэй хүний ажиллах чадвар эрэгтэй хүнийхтэй адил, эрт тэтгэвэрт гарахаар тэдний орлого буурдаг, ажиллах бололцоог хааснаар тэдний нийгмийн идэвхи багасч байна гэсэн шалтгааныг дурджээ. Эмэгтэйчүүд гэр орон, үр хүүхдээ асрах ачаалал ихтэй байдаг болохоор эрэгтэйчүүдтэй адилхан наснаас тэтгэвэрт гарах нь буруу гэж нийт оролцогчдын тал хувь нь үзсэн байна. Олон хүүхэдтэй эмэгтэйчүүд тэтгэврийн наснаас 5 жилийн өмнө тэтгэвэр тогтоолгож байгаа нь зөв гэж нийт хүмүүсийн 86.7 хувь нь үзсэн байна. Харин нийт оролцогчдын 8.4 хувь нь олон хүүхэд гарган эрт тэтгэвэрт гарснаар нийгэм, хамт олноос хөндийрч байна, 9.3 хувь нь орлого олох бололцоог хааж байна гэсэн шалтгаанаар эрт тэтгэвэрт гаргахыг буруу гэж үзэж байна.

Судалгаанаас Нийгмийн даатгалын хуульд заасан 20-иос доошгүй жил ажилласан 55 настай эмэгтэй, 60 настай эрэгтэй хүн тэтгэвэр тогтоолгох эрхтэй байгаа заалт өнөөгийн нөхцөл байдалд нийцэж байна гэж дүгнэж болохоор байна. Мөн эрэгтэйчүүд дунджаар 13,3 жил, эмэгтэйчүүд 15,3 жил тэтгэвэр авч байгаа нь тогтоогдлоо. 2030 оноос хойш хүмүүсийн тэтгэвэр авах дундаж хугацаа эрэгтэйчүүдэд 15,4 жил, эмэгтэйчүүдэд 17,1 жил болно.

## Судалгааны зорилго:

Монгол хүний тэтгэвэрт гарах насыг 1) олон нийтийн санаа бодлыг судлан; 2) тэтгэвэр тогтоолгосноос хойш амьдарсан жилийг түүвэр байдлаар судлан тогтоох, цаашдын прогнозыг хийх зорилгоор энэхүү судалгааг хийсэн болно.

## 1. Монгол хүний тэтгэвэр тогтоолгох нас

Монгол улсын нийгмийн даатгалын хуулийн дагуу 60 нас хүрсэн, нийгмийн даатгалын шимтгэлийг зохих хугацаанд төлсөн иргэн тэтгэвэр тогтоолгох эрхтэй боловч ажлын онцлог, хөдөлмөрийн нөхцөл, хүйс зэргээс хамаарч иргэд харилцан адилгүй наснаас тэтгэвэр тогтоолгож байна. Тухайлбал:

1. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан бол 45-50 наснаас
2. 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эмэгтэй 50 нас, бусад эмэгтэй 55 наснаас
3. Цэргийн бага, дунд тушаалын албан хаагчид 20-25 жил ажилласан бол 40-45 наснаас
4. Төрийн захиргааны албан хаагчид өөрөө хүсэж, дээд дарга нь зөвшөөрвөл эрэгтэй 65, эмэгтэй 60 наснаас тэтгэврээ тогтоолгож байна. Тэтгэврийн насны энэ тогтолцоог нарийвчлан судлаж үзвэл төрийн болон цэргийн өндөр албан тушаалын ажиллагсад олон жил /65 нас хүртэл/ ажиллах, бага, дунд тушаалын



албан хаагчид харьцангуй эрт тэтгэвэрт гарах асуудлыг хуулиар зохицуулжээ. Судлаачдын тооцоолсноор нийт тэтгэвэр авагчдын зөвхөн 25 хувь нь 60 нас хүрсэн үедээ тэтгэвэрээ тогоолгожээ. Өөрөөр хэлбэл нийт тэтгэвэр авагчдын 75 хувь нь 60 наснаас өмнө тэтгэвэр тогтоолгодог байна. Эндээс үндэслэн тэтгэвэрт гарах насыг зөв, оновчтой тодорхойлон хуульчлах шаардлага тавигдаж байна.

Тэтгэврийн насыг оновчтой тогтооход хүн амын дундаж наслалт, тэтгэвэрт гарсан иргэдийн амьдрах дундаж хугацаа чухал үзүүлэлт болдог. ҮСГ-аас гаргасан мэдээгээр 2005 оны байдлаар хүн амын дундаж наслалт эрэгтэй 63.8, эмэгтэй 68.1 жил байгаа бөгөөд 2025 он гэхэд эрэгтэй 68.8, эмэгтэй 73.4 болно гэж урьдчилан тооцоолжээ.

Сүүлийн жилүүдэд Австрали, Австри, Бельги, Герман, Грек, Итали, Португал, Швейцарь, Их Британи улс эмэгтэйчүүдийн тэтгэвэр тогтоолгох насыг уртасгажээ. Харин АНУ, Япон улсад эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэтгэвэр тогтоолгох насыг адилхан нэмсэн байна. Барууны хөгжилтэй орнуудад тэтгэвэрт гарах насыг ихэвчлэн 65 – аар тогтоосон байна.

Гэхдээ тэтгэврийн насыг шинэчлэн тогтоох асуудал нь улстөрийн шийдэл шаарддаг, төр,

захиргааны эрх барьж байгаа байгууллагын нийгмийн хамгааллын үзэл баримтлал, улс орны эдийн засгийн чадавхи, санхүүгийн боломжоос ихээхэн хамаардаг.

## 2. Тэтгэврийн насны иргэдийн талаар

Тэтгэврийн насны хүн ам 2000 онд 153.8 мянга байсан бол 2025 он гэхэд 434.5 мянга болж 2000 оноос 1.8 дахин өсөх төлөвтэй. Тэтгэврийн насны хүн амыг хүйсээр нь авч үзвэл 2000 онд нийт тэтгэврийн насны хүн амын 64.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байсан бол 2025 онд 63.4 хувь болж 0.6 пунктаар буурах хандлагатай байна.

2000 онд тэтгэврийн насны иргэд нийт хүн амын 6.4 хувийг эзлэж байсан бол 2025 онд 14.7 хувь болж нэмэгдэх төлөвтэй байна.

Тэтгэврийн насны хүн ам 2000-2005 онд 12.7 хувь өсч байснаа 2010-2020 онд 33.5 хувь болж эрс нэмэгдэж, харин 2025 онд 29.8 хувь болж бага зэрэг буурах хандлага ажиглагдаж байна.

Тэтгэврийн насны хүн амын харьцангуй хурдан өсөлт нь хөдөлмөрийн нөөцийн өсөлтөөс 29.1-ээс 31.3 пунктаар түрүүлэх бөгөөд ингэснээр ажил хөдөлмөр эрхлэх нэг хүнд ноогдох нийгмийн ачаалал эрс нэмэгдэх хандлагатай байна.

Он	2000	2005	2010	2015	2020	2025
Тэтгэврийн насны нийт хүн	153852	173345	199464	250754	334740	434561
Үүнээс: Эмэгтэй	98485	107852	127064	163842	218653	275715
Эрэгтэй	55367	65494	72400	86912	116087	158846

\* «Монгол хүний тэтгэврийн насанд нөлөөлж буй нийгэм ахуйн хүчин зүйлийн судалгаа», төсөлт ажлын тайлан, 2006




Хүснэгт 2. Нийт хүн амд тэтгэврийн насны хүн амын эзлэх хувь

Он	2000	2005	2010	2015	2020	2025
Бүгд	6.4	6.9	7.5	9.0	11.6	14.7
Үүнээс: Эмэгтэй	8.2	8.5	9.4	11.6	14.9	18.2
Эрэгтэй	4.7	5.2	5.5	6.3	8.2	11.0

Хүснэгт 3. Тэтгэврийн насны хүн амын өсөлтийн хувь

Он	2000-2005	2005-2010	2010-2015	2015-2020	2020-2025
Тэтгэврийн насны нийт хүн					
Үүнээс: Эмэгтэй	12.7	15.1	25.7	33.5	29.8
Эрэгтэй	9.5	17.8	28.9	33.5	26.1
Эрэгтэй	18.3	10.5	20.0	33.6	36.8



### 3. Тэтгэврийн насны талаарх нийгмийн хандлага

Монгол хүний хөдөлмөрийн чадвараа бүрэн ашиглаж чадах насанд нөлөөлж байгаа нийгэм, ахуйн хүчин зүйлийн талаар олон нийтийн санал, бодлыг судлах, тэтгэврийн насны зохистой харьцаа, тэтгэврийн нас болон ажил, мэргэжлийн ялгамжтай байх зарчим үндэслэл, үр дагаврыг тодотгох, санал дэвшүүлэх зорилгоор хийгдсэн судалгааны үр дүнг одоо товч танилцуулая.

#### 3.1 Судалгаанд оролцогчдын нас, хүйс, боловсролын байдал


Энэхүү судалгаанд Улаанбаатар хотын 6 дүүрэг, Дориод, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий, Увс, Сэлэнгэ, Орхон аймгийн нийт 2436 хүн хамрагджээ (Хүснэгт

1). Судалгаанд хамрагдагчдыг байршлаар нь авч үзвэл 24.7 хувь нь Улаанбаатар хотод, 16.3 хувь нь аймгийн төвд, 40.3 хувь нь сумын төвд, 18.7 хувь нь хөдөөд амьдарч байна.

Нийт судалгаанд оролцогчдын 53.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийг боловсролын түвшингээр нь авч үзвэл; тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүмүүс 44.5 хувийг, дээд боловсролтой хүмүүс 31.0 хувь, бага боловсролтой хүмүүс 21.1 хувийг тус тус эзэлж байна. Харин нийт хүмүүсийн 3.4 хувь нь ямар ч боловсролгүй хүмүүс байв.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийг насны бүлгээр Зураг 2-д үзүүлэв. Нийт хамрагдагчдын дөрвөн хүний нэг нь 40-49 насныхан, таван хүний нэг нь 50-59 насныхан байна.





Харин ажилласан жилээр нь авч үзвэл 30.2 хувь нь 20-29 жил, 22.1 хувь нь 30-39 жил, 21.2 хувь нь 10-19 жил, 20.0 хувь нь 0-9 жил, 5.1 хувь нь 40-49 жил ажилласан хүмүүс байна. Хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь авч үзвэл 40.1 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч, 2.6 хувь нь иргэний гэрээгээр ажиллагч, 16.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 8.5 хувь нь өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч, 4.8 хувь нь хоршооллын гишүүн, 3.3 хувь нь ажил олгогчид байна.

### 3.2 Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэтгэвэр тогтоолгох насны тухай

#### Эрэгтэйчүүдийн тухай

Судалгаанд хамрагдагсдын 79.0 хувь нь 60 наснаас хойш эрэгтэй хүний хөдөлмөрийн чадвар буурдаг, ажлын байр цөөн, ажилгүйдэл их байгаа, эрэгтэй хүний дундаж наслалт бага байдаг, энэ наснаас тэтгэвэрт гаргах нь зөв зэргийг харгалзан, өөрөөр хэлбэл, нийгмийн даатгалын хуульд заасны дагуу 20-иос доошгүй жил ажилласан 60 настай эрэгтэй хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгох нь зүйтэй гэж үзсэн байна. Харин 19.3 хувь нь буюу 470 хүн эрт тэтгэвэрт гаргаж ажиллах бололцоог хааж байна, эрэгтэй хүний дундаж нас харьцангуй өссөн, авч байгаа тэтгэврийн хэмжээ бага, амьжиргааны өртгийг нөхөхгүй байгаа, хүний амьдралын хэмнэл, идэвхид сөргөөр нөлөөлдөг гэсэн шалтгаанаар нийгмийн даатгалын хуульд заасны дагуу 20-иос доошгүй жил

ажилласан 60 настай эрэгтэй хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгодог байдлыг манай нөхцөлд төдийлөн тохирохгүй байна иймд эргэж харах нь зүйтэй гэсэн байр суурийг илэрхийлсэн байна.

Эрэгтэй хүний тэтгэвэрт гарах хамгийн зохимжтой нас 60 гэж үзсэн хүмүүс судалгаанд хамрагдагчдын 67.0 хувийг эзэлж байна.

Тэтгэвэр тогтоолгохын тулд эрэгтэйчүүд 20-иос дээш жил ажилласан байх ёстой гэж нийгмийн даатгалын хуульд заасан заалттай дийлэнхи нь санал нэг байгаа нь харагдаж байна.

#### Эмэгтэйчүүдийн тухай

Судалгаанд хамрагдагсдын 76.6 хувь нь 55 наснаас хойш эмэгтэй хүний хөдөлмөрийн чадвар буурдаг, ажлын байр цөөн, ажилгүйдэл их байгаа нөхцөлд энэ наснаас тэтгэвэрт гаргах нь зөв гэсэн шалтгаанаар нийгмийн даатгалын хуульд заасны дагуу 20-иос доошгүй жил ажилласан 55 настай эмэгтэй хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгох нь зүйтэй гэж үзсэн байна. Харин 22.4 хувь нь өрхийн орлогын хэмжээ багасч байна, ажиллах чадвартай ч бололцоог нь хааж байна, эмэгтэй хүний дундаж нас харьцангуй өссөн гэсэн шалтгаанаар нийгмийн даатгалын хуульд заасны дагуу 20-иос доошгүй жил ажилласан 55 настай эмэгтэй хүн өндөр насны тэтгэвэр тогтоолгох нь буруу гэж үзжээ.



Эмэгтэй хүний тэтгэвэрт гарах хамгийн зохимжтой нас 50-59 нас гэж үзсэн хүмүүс судалгаанд хамрагдагчдын 87.6 хувийг эзэлж байна.

Тэтгэвэр тогтоолгохын тулд эмэгтэйчүүд 20-иос дээш жил ажилласан байх ёстой гэж нийгмийн даатгалын хуульд заасан заалттай дийлэнхи нь (81.4 хувь) санал нэг байна.

*Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэтгэвэр тогтоолгох нас ялгавартай байгааг өөрчлөх талаар*

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэтгэвэр тогтоолгох нас ялгавартай байгааг өөрчилж, адил насандаа тэтгэвэр тогтоолгодог болохыг нийт судалгаанд оролцогчдын 37.4 хувь нь зөв, 55.1 хувь нь буруу, 7.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Тэтгэврийн насыг ижил байлгах нь зөв гэж үзсэн хүмүүсийн 20 гаруй хувь нь эмэгтэй хүний ажиллах чадвар эрэгтэй хүнийхтэй адил, эрт тэтгэвэрт гарахаар тэдний орлого буурдаг, ажиллах бололцоог хааснаар тэдний нийгмийн идэвхи багасаж байна гэсэн шалтгаанаар тэтгэвэрт гарах насны хэмжээ ижил байх ёстой гэжээ. Мөн энэ өөрчлөлтийг 2007 оноос эхлэн хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна. Эмэгтэйчүүд гэр орон, үр хүүхдээ асрах ачаалал ихтэй байдаг болохоор эрэгтэйчүүдтэй адилхан наснаас тэтгэвэрт гаргах нь буруу гэж нийт оролцогчдын тал хувь нь үзсэн байна.

Олон хүүхэдтэй эмэгтэйчүүд тэтгэврийн наснаас 5 жилийн өмнө тэтгэвэр тогтоолгож байгаа нь зөв гэж нийт хүмүүсийн 86.7 хувь нь үзсэн байна. Харин нийт оролцогчдын 8.4 хувь нь олон хүүхэд гарган эрт тэтгэвэрт гарснаар нийгэм, хамт олноос хөндийрч байна, 9.3 хувь нь орлого олох бололцоог хааж байна гэсэн шалтгаанаар эрт тэтгэвэрт гаргахыг буруу гэж үзэж байна. Олон хүүхэдтэйн нөхцлөөр 50 настай тэтгэвэр тогтоолгодог журмыг өөрчилж нийт эмэгтэйчүүдтэй адилтгаж 55 наснаас тэтгэвэрт гаргах нь зөв үү гэсэн асуултанд нийт хүмүүсийн 56.6 хувь нь буруу, олон хүүхэдтэйн нөхцлөөр тэтгэвэрт гарах журмыг өөрчилж болохгүй гэсэн байна.

Газрын дор, хортой, халуун нөхцөлд ажиллаж байгаа эрэгтэй хүн 50, эмэгтэй хүн 45 насандаа өндөр насны тэтгэвэрт гарч байгаа явдлыг 91.8 хувь нь зөв гэж үзсэн байна. Ийм нөхцөлд ажилласан хүмүүсийн эрүүл мэнд муудаж, хөдөлмөрлөх чадваргүй болдог, бусад хүмүүстэй харьцуулахад насжилт богино байдаг учраас энэ насанд тэтгэвэрт гаргах нь зөв гэжээ.

Цэргийн албан хаагчид эрт тэтгэвэр тогтоолгох нь зөв гэж нийт оролцогчдын 60.0 хувь нь үзсэн бол, 35.1 хувь нь буруу, 4.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

Малчдын тэтгэврийн насыг тусгайлан тогтоож болох үү гэсэн асуултанд 50.5 хувь нь болно, 42.3 хувь нь болохгүй, 6.9 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. Тусгайлан тогтоож болно гэж хариулсан хүмүүсийн 42.5 хувь нь эрэгтэйчүүдийг 60 наснаас, 42.3 хувь нь эмэгтэйчүүдийг 50 наснаас нь тэтгэвэрт гаргах нь зөв гэжээ. Харин нийт иргэдийн тэтгэврийн нас адилхан байх ёстой, тусгайлан үзэх шалтгаан байхгүй гэсэн үүднээс малчдын насыг тусгайлан тогтоох шаардлагагүй гэж үзсэн байна.

### 3.3 Тэтгэврийн насны хүний асуулга

Энэ асуулгыг судалгаанд хамрагдсан зөвхөн тэтгэврийн насны хүмүүсээс асуусан болно. Нийт судалгаанд хамрагдагчдын 31.4 хувь буюу 764 хүн нь тэтгэврийн насны хүмүүс байна. Эдгээр хүмүүсийн 16.1 хувь нь тэтгэвэр тогтоолгоод 0-9 жил, 13.1 хувь нь 10-19 жил, 1.8 хувь нь 20-29 жил болж байгаа ажээ.

Эдгээр хүмүүсийн ажиллаж байсан үеийнх нь ажлын байрны нөхцлийн талаар тодруулахад, 24.8 хувь нь хэвийн, 3.6 хувь нь хүнд, 1.5 хувь нь хортой, 0.9 хувь нь халуун, 0.5 хувь нь газрын дор ажиллаж байсан байна.

Нийт тэтгэвэрт байгаа хүмүүсийн 16.9 хувь нь тэтгэврийн насаар, 6.5 хувь нь олон хүүхэдтэйн нөхцлөөр, 5.0 хувь нь ажилласан жилээр, 1.6 хувь нь цэргийн албан хаагчаар, 1.2 хувь нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцлөөр тэтгэврээ тогтоолгосон байна.



Тэтгэвэрт гарсны дараа эдгээр хүмүүсийн 18.2 хувь нь орлого буурсан, 6.8 хувь нь орлого хэвийн байгаа, 4.2 хувь нь орлого нэмэгдсэн гэж хариулжээ. Тэтгэвэр авагчдын 17.6 хувь нь хүрэлцдэггүй, амьжиргаандаа нэмэр болох зорилгоор ажил хийж байна.

Өөрийгөө тэтгэвэрт гарснаа юу гэж үздэг талаар лавлахад хууль номондоо заасан хугацаа нь болсон болохоор гэж дийлэнхи нь хариулсан байна. Тэтгэврийн хэмжээ нь амьдралын баталгаа болж чадаж байгаа эсэхэд 26.2 хувь нь чадахгүй байна, 5.0 хувь нь чадаж байна гэжээ. Нийгмийн даатгалын шимтгэл тэтгэврийн хэмжээнд нөлөөлсөн эсэх талаар асуухад 14.0 хувь нь нөлөөлсөн, 4.7 хувь нь үгүй, 12.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

### 3.4 Ажиллагчид

Нийт судалгаанд хамрагдагчдын 49.6 хувь буюу 1209 хүн ажил эрхэлж байв. Эдгээр хүмүүсийн 30.9 хувь нь 10 ба түүнээс дээш жил, 7.8 хувь нь 5-9 жил, 4.2 хувь нь 3-4 жил, 3.5 хувь нь 1-2 жил, 3.0 хувь нь 1 жил хүртэл хугацаагаар тус тус эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байна.

Одоогийн ажлаа хэдэн нас хүртэл хийх боломжтой гэж үзэж байгаа талаар асуухад 15.0 хувь нь 55 нас, 14.2 хувь нь 50 нас, 11.6 хувь нь 60 нас, 8.7 хувь нь 65 ба түүнээс дээш нас хүртэл гэж хариулсан байна.

Ажлын байрны нөхцлийн хувьд; 42.3 хувь нь хэвийн, 4.2 хувь нь хүнд, 1.8 хувь нь хортой, 0.8 хувь нь халуун, 0.5 хувь нь газрын дор ажиллаж байна гэж хариулсан байна. Нийт ажиллагчдын 2.3 хувь нь машин механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл болон хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласнаас үйлдвэрлэлийн осолд өртсөн байна.

Үйлдвэрлэлийн ослын улмаас 1.6 хувь нь хөдөлмөрийн чадвараа түр алдсан, 0.4 хувь нь ажлын байраа сольсон, 0.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

## 4. Өнөөгийн тэтгэврийн тогтолцооны дагуу тэтгэвэрт гарч байгаа иргэдийн тэтгэвэр авч байгаа дундаж хугацааны судалгаа

Түүврийн төлөөллийн талаар: Монгол хүний тэтгэвэр авч байгаа дундаж хугацааг судлан тогтоохын тулд бид Улаанбаатар хотын 7 дүүргийн архивын материалаас 1172 тэтгэвэр авч байгаад нас барсан хүний мэдээллийг түүвэр байдлаар авлаа. Үр дүнг нэгтгэн харуулбал,

Баянгол дүүргээс	148
Баян зүрх дүүргээс	152
Налайх дүүргээс	238
Сүхбаатар дүүргээс	225
Сонгино хайрхан дүүргээс	148
Хан-Уул дүүргээс	76
Чингэлтэй дүүргээс	185
Бүгд	1172

Эдгээр хүмүүсийг хүйсээр нь ангилж үзвэл эрэгтэй 633, эмэгтэй 537 хүний материал судалгаанд хамрагдсан юм.


Тэтгэвэр тогтоолгосон нөхцлөөр нь ангилж үзэхэд хэвийн нөхцлөөр 727, хүнд хортой, газрын доорх нөхцлөөр 192, олон хүүхэдтэй эхчүүдээр 119, хувь тэнцүүлэн 39, цэргийн албан хаагчаар 93 хүн тус бүр тэтгэврээ тогтоолгожээ.

### 4.1 Товч үр дүн

Судалгааны материалын математик тооцооллыг «Минитаб» статистикийн программаар гүйцэтгэсэн. Судалгаанд хамрагдсан 633 эрэгтэй хүний мэдээллийг программд оруулж, гистограммыг зуруулан ажилласан жил, тэтгэвэр тогтоолгосон нас, тэтгэвэр авсан хугацаа, эдгээрийн стандарт хазайлтыг тооцуулахад эрэгтэйчүүд тэтгэвэр тогтоолгосноосоо хойш дунджаар 13,3 жил тэтгэвэр авч байгаа, стандарт хазайлт нь 6,8 жил гэсэн үр дүн гарч байна. Энэ нь өнөөгийн байдлаар эрэгтэйчүүд 13,3 ± 6,8 жил тэтгэвэр авч байна гэсэн үг юм.



Энэ мэтчилэн хүйс болон тэтгэвэр тогтоолгосон нөхцөл тус бүрээр уг тооцооллыг хийж зургаар үзүүлэн хавсаргалаа.



Тооцооллын үр дүнг нэгтгэн харуулбал:

**А. Эрэгтэйчүүд**

Үзүүлэлтүүд	Ажилсан жил	Тэтгэвэрт гарсан нас	Тэтгэвэр авсан жил
Дундаж үзүүлэлт	28,6	58,6	13,3
Стандарт хазайлт	7,7	7,1	6,77
Түүврийн хэмжээ, n	633	633	633

Эрэгтэйчүүд дунджаар 28,6 жил ажиллаад 58,6 настайдаа тэтгэвэрт гарч 13,3 жил тэтгэвэр авдаг байна.

**В. Эмэгтэйчүүд**

Үзүүлэлтүүд	Ажилсан жил	Тэтгэвэрт гарсан нас	Тэтгэвэр авсан жил
Дундаж үзүүлэлт	22,2	54,6	15,3
Стандарт хазайлт	11,1	7,4	7,2
Түүврийн хэмжээ, n	537	537	537

Эмэгтэйчүүд дунджаар 22,2 жил ажиллаад 54,6 настайдаа тэтгэвэрт гарч 15,3 жил тэтгэвэр авдаг байна.

**С. Хэвийн нөхцлөөр тэтгэвэрт гарсан хүмүүс**

Үзүүлэлтүүд	Ажилсан жил	Тэтгэвэрт гарсан нас	Тэтгэвэр авсан жил
Дундаж үзүүлэлт	26,9	58,5	14,0
Стандарт хазайлт	11,2	6,9	7,3
Түүврийн хэмжээ, n	727	727	727

Хэвийн нөхцлөөр тэтгэвэрт гарсан хүмүүс дунджаар 26,9 жил ажиллаад 58,5 настайдаа тэтгэвэрт гарч 14,0 жил тэтгэвэр авдаг байна.

**D. Хэвийн бус нөхцлөөр тэтгэвэрт гарсан хүмүүс**

Үзүүлэлтүүд	Ажилласан жил	Тэтгэвэрт гарсан нас	Тэтгэвэр авсан жил
Дундаж үзүүлэлт	24,2	53,7	14,2
Стандарт хазайлт	5,8	7,3	6,9
Түүврийн хэмжээ, n	192	192	192

Хэвийн бус нөхцлөөр тэтгэвэрт гарсан хүмүүс дунджаар 24,2 жил ажиллаад 53,7 настайдаа тэтгэвэрт гарч 14,2 жил тэтгэвэр авдаг байна.

**E. Олон хүүхэдтэй эхчүүдийн нөхцлөөр тэтгэвэрт гарсан хүмүүс**

Үзүүлэлтүүд	Ажилласан жил	Тэтгэвэрт гарсан нас	Тэтгэвэр авсан жил
Дундаж үзүүлэлт	20,9	51,7	15,1
Стандарт хазайлт	5,4	5,6	6,1
Түүврийн хэмжээ, n	119	119	119

Олон хүүхэдтэй эхчүүдийн нөхцлөөр тэтгэвэрт гарсан хүмүүс дунджаар 20,2 жил ажиллаад 51,7 настайдаа тэтгэвэрт гарч 15,1 жил тэтгэвэр авдаг байна.

**F. Хувь тэнцүүлсэн тэтгэвэр авдаг хүмүүс**

Үзүүлэлтүүд	Ажилласан жил	Тэтгэвэрт гарсан нас	Тэтгэвэр авсан жил
Дундаж үзүүлэлт	17,1	60	15,3
Стандарт хазайлт	8,8	6,4	6,9
Түүврийн хэмжээ, n	39	39	39

Хувь тэнцүүлсэн тэтгэвэр авдаг хүмүүс дунджаар 17,1 жил ажиллаад 60 настайдаа тэтгэвэрт гарч 15,3 жил тэтгэвэр авдаг байна.

**G. Цэргийн албан хаагчаар тэтгэвэрт гарсан хүмүүс**

Үзүүлэлтүүд	Ажилласан жил	Тэтгэвэрт гарсан нас	Тэтгэвэр авсан жил
Дундаж үзүүлэлт	28,6	54,7	14
Стандарт хазайлт	7,1	9,5	6,1
Түүврийн хэмжээ, n	93	93	93

Цэргийн албан хаагчаар тэтгэвэрт гарсан хүмүүс дунджаар 28,6 жил ажиллаад 54,7 настайдаа тэтгэвэрт гарч 14 жил тэтгэвэр авдаг байна.

Бидний хийсэн судалгааны үр дүнд өнөөгийн тогтолцоогоор эрэгтэйчүүд дунджаар 13,3 жил, эмэгтэйчүүд 15,3 жил тэтгэвэр авч байгаа нь тогтоогдлоо.

Хэтийн таамаглал: Цаашид хүмүүсийн тэтгэвэр авах дундаж хугацаа хэрхэн өөрчлөгдөхийг таамаглахын тулд 2000-2005 оны 60-аас дээш насны хүмүүсийн нас баралтын байдалд судалгаа хийж 1000 хүнд

ногдох нас баралтыг хүйсийн ялгаатайгаар гаргалаа. Үр дүнд нь өнөөгийн байдлаар 60-аас дээш насны 1000 эмэгтэй хүнд ногдох нас баралт дунджаар 48,6 хүн, 1000 эрэгтэй хүнд ногдох нас баралт дунджаар 66 хүн гэж гарч байна. Тэгвэл дундаж наслалт эмэгтэйчүүдийнх 68,6, эрэгтэйчүүдийнх 62,1 байгаа юм.

Энэ үр дүнг ашиглан 2030 он хүртэлх хүмүүсийн тэтгэвэр авах дундаж хугацааг шугаман регрессийн загвараар дараахь байдлаар үнэлж тогтоов. Загварын тэгшитгэлийг бичвэл:



$$y = kx$$

Үүнд:

$y$  - 2025 - 2030 оны дундаж наслалт

$x$  - өнөөгийн дундаж наслалт

$k$  - нас баралтын ахиу үзүүлэлт

Монгол Улсын ҮСГ-ын газраас 2025 онд эрэгтэйчүүдийн дундаж наслалт 70, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 74,7 болно гэсэн тооцоо гаргасан. (Эх сурвалж: Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо, ҮСГ, 2002 он) Эдгээрийг доод хязгаар болгон авч, дээд хязгаарыг харгалзан 72, 76,7 гэж өгөн 1000 хүнд ногдох 60-аас дээш насны хүмүүсийн нас баралтыг тооцё.

Доод хязгаар нь: Дундаж наслалт 70 гэж үзээд

$$y_1 = \frac{70 * 66}{62.1} = 74.4 \text{ болно.}$$

Дээд хязгаар нь: дундаж наслалт 72 гэж үзээд

$$y_2 = \frac{72 * 66}{62.1} = 76.5$$

Энэ нь 2025-2030 онд 1000 хүнд ноогдох эрэгтэй хүний нас баралт [74.4; 76.5] болно гэсэн үг юм.

Эмэгтэй хүний тухайд:

Доод хязгаар нь дундаж наслалтыг 74,7 гээд

$$y_1 = \frac{74.7 * 48.6}{68.6} = 52.9$$

Дээд хязгаар: дундаж наслалтыг 76,7 болно гэвэл

$$y_2 = \frac{76.7 * 48.6}{68.6} = 54.3$$

Эрэгтэй:

$$y_1 = \frac{13.3 * 74.4}{66} = 15.0 \quad y_2 = \frac{13.3 * 76.5}{66} =$$

Тэтгэвэр авах дундаж хугацаа эрэгтэй хүний хувьд [15.0; 15.4] болно.

Эмэгтэй:

$$y_1 = \frac{52.9 * 15.3}{48.6} = 16.6 \quad y_2 = \frac{54.3 * 15.3}{48.6} = 17.1$$

Тэтгэвэр авах дундаж хугацаа эмэгтэй хүний хувьд [16.6; 17.1] болж байна.

### Дүгнэлт

\* Нийгмийн даатгалын хуульд заасан 20-иос доошгүй жил ажилласан 55 настай эмэгтэй, 60 настай эрэгтэй хүн тэтгэвэр тогтоолгох эрхтэй байгаа заалт өнөөгийн нөхцөл байдалд нийцэж байна гэж үзэж болохоор байна.

\* Өнөөгийн тогтолцоогоор эрэгтэйчүүд дунджаар 13,3 жил, эмэгтэйчүүд 15,3 жил тэтгэвэр авч байгаа нь тогтоогдлоо

\* 2030 оноос хойш хүмүүсийн тэтгэвэр авах дундаж хугацаа эрэгтэйчүүдэд 15,4 жил, эмэгтэйчүүдэд 17,1 жил болох төлөвтэй байна.



## Ашигласан материал

1. Үндэсний Статистикийн Газар, 2006, Монгол улсын статистикийн эмхтгэл, 2005, Улаанбаатар
2. НХХЯ, 2006. «Монгол хүний тэтгэврийн насанд нөлөөлж буй нийгэм ахуйн хүчин зүйлийн судалгаа», төсөлт ажлын тайлан, Улаанбаатар
3. Үндэсний Статистикийн Газар, 2002. Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо: 2000 оны Хүн ам, орон сууцны тооллого, Улаанбаатар